



I-III/2022

Тархаасан: 2022 оны 4 дүгээр сарын 13




## Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого өмнөх улирлаас 23 тохиолдлоор буурлаа

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын мэдээллээр үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдол 2022 оны эхний улиралд 62 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 17 (37.8%)-оор өссөн бол өмнөх улирлаас 23 (27.1%) -аар буурсан байна.

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын 15 (24.2%) тохиолдол унах бүдрэх, халтирснаас үүссэн бол унаж байгаа эд зүйлд цохигдсон 7 (11.3%), гадны халдлагад өртсөн 7 (11.3%), хүчилсэн болон хүчтэй хөдөлгөөнд өртсөн 6 (9.7%), эд зүйлд хавчуулагдсан 3 (4.8%), эд зүйл дээр гишгэсэн суурин болон хөдөлгөөнт эд зүйлд цохигдсон 3 (4.8%), цахилгаан гүйдэлд цохиулсан 2 (3.2%), халсан, түлэгдсэн, хөлдсөн 2 (3.2%), бусад 17 (27.5%) тохиолдол бүртгэгдсэн байна.


Нийт осолдогчдын 25 (40.3%) нь хөнгөн хэлбэрээр, 23 (37.1%) нь хүнд хэлбэрээр осолдож, 14 (22.6%) хүн нас барсан байна.

ЗУРАГ 1. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГО, бүсээр, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар



Нийт осолдогчдын 14 (22.6%) нь эмэгтэйчүүд байна. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдол 2022 оны эхний улиралд Баруун бүсэд 6 (9.7%), Хангайн бүсэд 7 (11.3%), Төвийн бүсэд 7 (11.3%), Зүүн бүсэд 9 (14.5%), Улаанбаатар хотод 33 (53.2%) бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 2. ОСОЛДОГЧИД, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар, 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар




Осолдогчдыг насны бүлгээр авч үзэхэд 18-24 насны 4 (6.5%), 25-34 насны 18 (29.0%), 35-44 насны 17 (27.4%), 45-59 насны 23 (37.1%) хүн байв.

ХҮСНЭГТ 1. ОСОЛДОГЧИД, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, жил бүрийн эхний улирлын байдлаар

Салбар	2020 I-III	2021 I-III	2022 I-III
<b>Дүн</b>	<b>84</b>	<b>45</b>	<b>62</b>
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	3	1	-
Уул уурхай, олборлолт	17	3	17
Боловсруулах үйлдвэрлэл	10	9	4
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	2	1	1
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	-	1	4
Барилга	-	1	-
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	4	1	-
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	18	2	1
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	-	2	-
Мэдээлэл, холбоо	-	1	1
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1	-	1
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	-	1	2
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	13	9	13
Боловсрол	6	-	2
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	6	6	6
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	4	7	10

Нийт осолдогчдыг эрхэлж байсан ажил мэргэжлээр нь авч үзвэл, энгийн ажил мэргэжилтэй хүн 22 (35.5%), зэвсэгт хүчний ажилтан, мэргэжилтэн 10 (16.1%), техникч болон туслах, дэд мэргэжилтэн 7 (11.3%), суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч 7 (11.3%), мэргэжилтэн 5 (8.1%), үйлдвэрлэл, барилга, гар урлалтай, холбоотой ажил, үйлчилгээний ажилтан 4 (6.5%), худалдаа үйлчилгээний ажилтан 3 (4.8%), контор, үйлчилгээний ажилтан 2 (3.2%), менежер 2 (3.2%) байна.

ЗУРАГ 3. ОСОЛДОГЧИД, ажил мэргэжлийн ангиллаар, дүнд эзлэх хувиар, 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар



## Ойлголт, тодорхойлолт

**Үйлдвэрлэлийн осол:** Хөдөлмөр эрхлэгч иргэн хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн үйлчлэлд өртөхийг ойлгоно.

**Хурц хордлого:** Цацраг болон биологийн идэвхт бодис, химийн хорт бодисын нөлөөгөөр хурц, цочмог хэлбэрээр богино хугацаанд хордохыг ойлгоно.

**Осолдогч:** Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн ажилтан, иргэнийг ойлгоно.

**Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн нэг ажилтан,** иргэнийг үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын нэг тохиолдол гэж үзнэ. Хэрвээ нэг осол, хордлогод нэгээс дээш тооны хүн өртсөн бол осолдогч тус бүрээр үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдол гэж тооцно.

**Бүлэг осол, хурц хордлого:** Нэг үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод 2, түүнээс дээш тооны ажилтан, иргэн өртөхийг ойлгоно.



## Эх үүсвэр:

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

## Ангилал, код:

ISCO-08 ажил, мэргэжлийн ангилал;

ISIC 4.0 эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал;

ICD-10 өвчний олон улсын ангилал

## Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

## Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 7 дугаар сарын 19

Нийгмийн статистикийн газрын  
дарга А.Амарбал  
Утас : (976-51)-264805

Нийгмийн статистикийн газрын Өрхөд  
суурилсан судалгааны хэлтсийн  
статистикч Н. Алтантүлхүүр  
Утас : (976-51)-265543



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212